

Тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн

1. Улсын тооллогын үндсэн дээр сан хөмрөгт байх үндсэн бичиг баримтыг шинэчлэн хөтөлж үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллах бэлтгэл ажлыг хангаж байна.
2. Үзмэрийн танхимд байгаа нийт 1052 үзмэрээс 700 үзмэр, эд өлгийн зүйл QR кодтой болж, 66,5% хувийг цахимд шилжүүлсэн байна.
3. Музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа Диваажингийн сүм, Цогтын цагаан балгас /макет хувилбар/ Ардын Хатанбаатар С.Магсаржавын дуулган бунханы дотор хэсгийг тус тус AR технологи руу шилжүүлсэн. QR код уншуулан 3D хувилбарыг гар утаснаас шууд харах боломжтой.
4. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Монгол гэр” үзэсгэлэн, Булган сумын ЕБСургуулиудад “Уламжлалт уяа зангилаа”, “Тооно туших”, “Сампин зангидах”, “Дөрвөөр бөөрөнхий сүлжих”, “Жирэм сүлжээ”, “Соёлын биет ба биет бус өв”, “Музейн цахимжилт”, “Хатанбаатар С.Магсаржавын дуулгат бунхан”, “Булган аймгийн музейн түүх”, “Музейн орчинд видео хийх, бичлэг засварлах заавар” сэдэвт 6 боловсролын хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлсэн байна. Нийт хамрагдсан хүний тоо: 11800
5. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Монгол гэр” үзэсгэлэн, “Алтаргана-2024” ОУ-ын наадам, Хутаг-Өндөр, Бугат, Хишиг- Өндөр, Булган сумын ерөнхий боловсролын 1, 2, 3-р сургуулийн суралцагч, багш ажилчдад 24 төрлийн 60 ширхэг контенттой Виртуал музей хүрч үйлчилсэн байна. /Үйлчлүүлсэн хүний тоо-1727/
6. Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд “Анхдагч алдартны өлгий нутгийн музей” номын нээлт, номын сантай хамтран “Үл мартагдах түүх” монгол бичгийн үзэсгэлэнг насанд хүрэгчид болон хүүхдүүдийн дунд зохион байгуулж нийт 34 дэсийн 36 үзмэр тавигдсан байна .
7. Олон Улсын Алтаргана 15-р их наадмын бэлтгэл ажлыг хангах,байгууллагын өнгө үзэмжийг сэргээх зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 359,0 сая төгрөгний их засвар хийгдэж, Соёлын үнэт зүйлсийг иргэдэд чанар хүртээмжтэй, тав тухтай орчинд хүргэх зорилгоор гадна фассад, тааз, шал, хана, агааржуулалтын хоолой, үзмэрийн гэрэлтүүлэг, сантехникийн ажлуудыг бүрэн шинэчилж улсын комисст хүлээлгэн өгсөн
8. “Музейн нээлттэй өдрүүд” арга хэмжээний хүрээнд “Дайчин вангийн хүрээний шашин соёл”, Хутаг-Өндөр сумын 100 жилийн ой “Ардын Хатанбаатар С.Магсаржавын эд өлгийн зүйл, “Алтаргана-2024” олон улсын наадмын хүрээнд гаргасан “Буриад угсаатан”, “Айраг фестиваль-2024” арга хэмжээнд “Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн”, “Эв нэгдлийн бэлэгдэл Их цагаан суварга”-ны нээлт уран зургийн үзэсгэлэн, “Номын баяр-2024” арга хэмжээнд Номын сантай хамтран “Үл мартагдах түүх”, “Хуучин номын үзэсгэлэн”, Соёлын ажилтны баярыг тохиолдуулан “Соёлын биет бус өвлөн уламжлагчид” фото үзэсгэлэн, Соёлын бүтээлч сар аяны хүрээнд “Анхдагч алдартны өлгий нутгийн музей” номын нээлт монгол бичгийн үзэсгэлэн, Булган аймгийн Урчуудын эвлэлтэй хамтран уран зургийн үзэсгэлэн, нийт 10 үзэсгэлэн гаргасан байна.
9. Соёлын яамнаас зохион байгуулсан “Соёлын сэргэлт 2024” үйл ажиллагааны хүрээнд “Гэр” үзэсгэлэн, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-2024” хойд бүсийн нэгдсэн арга хэмжээнд оролцлоо
10. Булган сумын 1-р сургуулийн дунд ангийн сурагчдад Соёлын биет өвийг таниулах аялал, Соёлын биет бус өвийн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж 75 суралцагчид хамрагдсан.
11. Гурванбулаг, Сэлэнгэ, Бүрэгхангай, Сайхан, Булган сумдуудаас 48 баримтат өв ирснээс чанарын шаардлага хангаж байгаа Сэлэнгэ сумын иргэн Дамдинжавын Галбадрахын “Цэнд” судар, Булган аймгийн Бүрэгхангай сумын Дархан багийн өндөр настан Ц.Намжилдуламын “Богд Зонхов”, Доржнамжум, Сундуйнжүд судрууд, Дашчойхорлин хийдийн “Шалши сахиус” гэх мэт 4 баримтат өвийг СӨҮТ рүү хүргүүлсэн байна.
12. 2024 онд Тэшиг сумын харьяат Б.Оюумаа, МУХБ С.Дамдинсүрэн, генерал Д.Баасандамба, иргэн Т.Бэхтөр, “Алтаргана-2024” олон улсын наадмын бэлэгдэл гэх мэт нийт 22 дэсийн 51 үзмэрийг бэлэг, хандиваар авсан.
13. Сандуйжавын Балжиннямынханы “Буурал манхан” Ми Дамба овогт Зундуйн Жамцынханы “Ухаарахуй Учрахуй”, ургийн номуудыг олж сурталчлах ажлыг зохион

байгуулж байна. Гурванбулаг сумаас Хотгойдын Сэцэд удмынхны угийн шастир, угийн зураглалын хамт ирсэн.

14. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Монгол гэр” үзэсгэлэнд “Зүү ороох хатгамал, суран сүлжмэл” боловсролын хөтөлбөрт тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн 197 иргэн хамрагдаж, виртуал музейг 3 иргэн үзэж сонирхсон байна. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах” сарын аяны хүрээнд аймгийн “Оргил бэйч” ТББ-тай хамтран нүүдлийн виртуал музей 29 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэгүй үйлчилсэн байна.
15. “Айраг фестиваль-2024” арга хэмжээний “Монгол гэр” үзэсгэлэнг зохион байгуулж оролцов. Тус үзэсгэлэнд 6 соёлын биет бус өв өвлөн уламжлагчид 28 төрлийн бүтээлээр оролцож гар урлалын бүтээлээ дэлгэн худалдсан бөгөөд нийт 516 хүнд үйлчлэн 5,450,000 төгрөгний орлого олсон байна.
16. “Алтаргана-2024” олон улсын наадмын “Ардын гар урлал үзэсгэлэн” уралдаан, “Үлгэрч, ерөөлч, магтаалчдын уралдаан”-ы ажлын хэсэгт орж, бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хариуцан ажилласан. Тус наадмын үеэр “Буриад угсаатан” үзэсгэлэн болон “Айрагтай музей”-г хэрэгжүүлж 1249 хүнд үйлчлэн 4,565,000 төгрөгний орлого олсон байна.